



**ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд өөрчлөлт оруулахыг
дэмжих тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 хэсэг, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 2.6 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны "Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын талаар авах зарим арга хэмжээний тухай" 286 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн а/823 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1." Дулааны гуравдугаар цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 1.4-д "Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь 100 % төрийн өмчит хувьцаат компани бөгөөд төрлийн хувьд хаалттай, хэлбэрийн хувьд хувьцаат байх бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийн 66 хувийг Эрчим хүчний яам, 34 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар тус тус хэрэгжүүлнэ" гэснийг "Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь 100 % төрийн өмчит хувьцаат компани бөгөөд төрлийн хувьд хаалттай, хэлбэрийн хувьд хувьцаат байна. Компанийн нийт хувьцааны 66 хувийн төлөөллийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34 хувийн төлөөллийг "Эрчист монгол" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани тус тус хэрэгжүүлнэ" гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжих тухай" 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Л.Хангал-Эрдэнэ)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И.ЛҮВСАНЦЭРЭН

1701040046